ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/98/НА-СТА-ТШ3


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр

Утас: 89306788, Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Ньюбаланс Аудит ХХК-ийн захирал Б. Лхагвадорж

Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com

Чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун

Утас: 99509636.Цахим хаяг: d.gerlee98@gmail.com

Аудиторын туслах: Т. Мөнхгэрэл, Холбогдох утас: 99011389
Цахим хаяг: tumurmunkh08@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....13
3. Аудитын тайлан....14
3.1 Ерөнхий зүйл....14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....15
3.4 Материаллаг байдал ....15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....16
3.8 Аудитын гол асуудал ....17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд....17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....17
4. Аудитын илрүүлэлт....17
4.1 Залруулсан алдаа....17
4.4 Зөвлөмж....18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| НА | Нягтлах ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.25 № 01/392
танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **80,728,932.88** | **92,985,252.48** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 729,702.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 729,702.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 729,702.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 79,999,230.88 | 92,985,252.48 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,377,400.00 | 3,233,100.00 |
| 35130 | Эм боох материал | 3,377,400.00 | 3,233,100.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,621,830.88 | 89,752,152.48 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,048,200.00 | 6,616,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 68,015,504.88 | 69,065,666.48 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,102,800.00 | 3,375,200.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,298,150.00 | 9,411,370.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,107,160.00 | 1,233,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,463,643,288.82** | **1,667,087,650.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,463,643,288.82 | 1,667,087,650.31 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,453,069,088.82 | 1,656,513,450.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,469,847,127.00 | 1,670,130,901.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -70,143,792.50 | -102,490,318.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 52,851,700.00 | 70,374,903.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,694,841.41 | -19,230,667.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,777,068.43 | 49,927,068.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,660,072.70 | -14,479,336.01 |

| | | | |
|---|---|---|---|
| 39217 | Ном | 2,091,900.00 | 2,280,900.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,544,372,221.70** | **1,760,072,902.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,183,679.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,183,679.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 2,183,679.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,183,679.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,542,188,542.70** | **1,760,072,902.79** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,542,188,542.70 | 1,760,072,902.79 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,443,649,921.70 | 1,661,534,281.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 132,107,906.09 | 131,378,204.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,311,542,015.61 | 1,530,156,077.70 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,544,372,221.70** | **1,760,072,902.79** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,761,522,109.00** | **668,803,167.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,309,858,109.00** | **204,690,367.08** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,309,858,109.00 | 204,690,367.08 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,309,858,109.00 | 204,690,367.08 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,309,858,109.00 | 204,690,367.08 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **74,782,400.00** | **70,852,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 376,881,600.00 | 393,260,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 261,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 261,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 74,782,400.00 | 70,590,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 74,782,400.00 | 70,590,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **444,162,175.20** | **450,189,104.99** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **444,162,175.20** | **450,189,104.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 409,998,425.85 | 435,590,334.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 265,358,885.65 | 275,839,930.00 |
| 210101 | Үндсэн цалин | 265,356,075.82 | 171,635,318.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,809.83 | 85,110,986.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 19,093,626.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,177,958.00 | 35,929,061.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,342,881.00 | 24,898,817.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,667,860.00 | 2,767,912.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,134,288.00 | 2,214,329.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 518,181.00 | 543,518.82 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,514,748.00 | 5,504,481.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 68,552,471.00 | 64,764,190.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,145,879.00 | 3,702,136.00 |
| 210302 | Түлш, халаалт | 62,919,192.00 | 60,247,054.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,487,400.00 | 815,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,066,480.00 | 6,656,138.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 2,403,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 708,140.00 | 1,205,540.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 830,100.00 | 1,065,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 711,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 288,240.00 | 1,269,498.40 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,452,529.00 | 15,476,660.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 320,000.00 | 697,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,132,529.00 | 14,779,060.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 443,958.35 |
| 210602 | Тавилга | 00.00 | 443,958.35 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 184,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 184,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 300,000.00 | 878,350.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 338,350.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 540,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,090,102.20 | 35,418,047.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 388,350.00 | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 919,800.00 | 996,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,781,952.20 | 34,221,347.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 34,163,749.35 | 14,598,770.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 370,000.00 | 1,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 370,000.00 | 1,200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,555,856.35 | 13,398,770.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,555,856.35 | 13,398,770.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,237,893.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,237,893.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,317,359,933.80** | **218,614,062.09** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,317,359,933.80** | **218,614,062.09** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл** | 65,274,634.00 | 790,771.00 | 112,238,909.71 | 178,304,314.71 |
| C03 | Дахин илэрхийл-сэн үлдэгдэл | 65,274,634.00 | 790,771.00 | 112,238,909.71 | 178,304,314.71 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -106,964.05 | -106,964.05 |
| C08 | **2020 оны 12 дугаар сарын 31-** | **75,848,834.00** | **22,689,787.00** | **1,443,649,921.70** | 1,542,188,542.70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **нээрх үлдэгдэл** | | | | |
| D01 | **2021 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл** | **75,848,834.00** | **22,689,787.00** | **1,443,649,921.70** | 1,542,188,542.70 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -729,702.00 | -729,702.00 |
| D03 | Дахин илэрхийл-сэн үлдэгдэл | 75,848,834.00 | 22,689,787.00 | 1,442,920,219.70 | 1,541,458,840.70 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 218,614,062.09 | 218,614,062.09 |
| D09 | **2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **75,848,834.00** | **22,689,787.00** | **1,661,534,281.79** | 1,760,072,902.79 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **451,664,000.00** | **464,112,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **451,664,000.00** | **464,112,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 376,881,600.00 | 393,260,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 261,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 261,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 74,782,400.00 | 70,590,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 74,782,400.00 | 70,590,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **442,133,000.00** | **430,956,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **442,133,000.00** | **430,956,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **407,969,250.65** | **416,357,330.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 264,877,907.96 | 274,244,256.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 219,343,587.93 | 196,738,741.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,103,220.03 | 64,226,699.00 |
| 210104 | Урамшуулал | 20,431,100.00 | 13,278,816.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,658,935.69 | 39,708,414.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,658,935.69 | 39,146,624.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 144,317.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 115,453.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 27,456.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 274,562.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 67,436,707.00 | 64,764,190.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,145,879.00 | 3,702,136.00 |
| 210302 | Түлш, халаалт | 61,918,428.00 | 60,247,054.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,372,400.00 | 815,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,750,020.00 | 4,884,840.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 365,400.00 | 334,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,689,540.00 | 1,205,540.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 830,100.00 | 1,065,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 244,100.00 | 90,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 973,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,380,880.00 | 1,215,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,342,250.00 | 24,119,880.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,697,400.00 | 111,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,948,350.00 | 22,892,280.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,696,500.00 | 1,116,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,102,800.00 | 2,272,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,102,800.00 | 2,272,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 184,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 184,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 300,000.00 | 878,350.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 338,350.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 540,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,500,630.00 | 5,301,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 388,350.00 | 837,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,112,280.00 | 4,464,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,163,749.35** | **14,598,770.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 370,000.00 | 1,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 370,000.00 | 1,200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,555,856.35 | 13,398,770.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,555,856.35 | 13,398,770.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,237,893.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,237,893.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,531,000.00** | **33,156,700.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,416,000.00** | **33,156,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,416,000.00** | **33,156,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,416,000.00 | 33,156,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,416,000.00 | 33,156,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-9,416,000.00** | **-33,156,700.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 115,000.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 463,851,000.00 | 450,452,230.00 | 13,398,770.00 | 97.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 463,851,000.00 | 450,452,230.00 | 13,398,770.00 | 97.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 462,651,000.00 | 449,252,230.00 | 13,398,770.00 | 97.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 268,620,100.00 | 274,244,256.00 | -5,624,156.00 | 102.1 |
| 210101 | Үндсэн цалин | 185,483,800.00 | 196,738,741.00 | -11,254,941.00 | 106.1 |
| 210102 | Нэмэгдэл | 66,540,100.00 | 64,226,699.00 | 2,313,401.00 | 96.5 |
| 210104 | Урамшуулал | 16,596,200.00 | 13,278,816.00 | 3,317,384.00 | 80.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,264,100.00 | 39,708,414.00 | -3,444,314.00 | 109.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,519,000.00 | 39,146,624.67 | -13,627,624.67 | 153.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,686,600.00 | 2,542,282.74 | 144,317.26 | 94.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,148,700.00 | 2,033,246.21 | 115,453.79 | 94.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 537,600.00 | 510,143.78 | 27,456.22 | 94.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,372,200.00 | 5,097,637.94 | 274,562.06 | 94.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 62,342,800.00 | 64,764,190.00 | -2,421,390.00 | 103.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,014,000.00 | 3,702,136.00 | 1,311,864.00 | 73.8 |
| 210302 | Түлш, халаалт | 56,408,800.00 | 60,247,054.00 | -3,838,254.00 | 106.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 920,000.00 | 815,000.00 | 105,000.00 | 88.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,619,600.00 | 5,382,040.00 | -762,440.00 | 116.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 334,800.00 | 334,800.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 1,205,540.00 | 294,460.00 | 80.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 988,000.00 | 1,065,400.00 | -77,400.00 | 107.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 279,000.00 | 279,000.00 | 0.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 711,800.00 | -211,800.00 | 142.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,017,800.00 | 1,785,500.00 | -767,700.00 | 175.4 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,816,900.00 | 24,119,880.00 | 26,697,020.00 | 47.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,600.00 | 111,600.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 49,589,300.00 | 22,892,280.00 | 26,697,020.00 | 46.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,116,000.00 | 1,116,000.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,670,400.00 | 34,670,100.00 | 300.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,438,700.00 | 18,438,700.00 | 0.00 | 100.0 |
| 210602 | Тавилга | 13,959,000.00 | 13,959,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,272,700.00 | 2,272,400.00 | 300.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 279,000.00 | 184,000.00 | 95,000.00 | 65.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 279,000.00 | 184,000.00 | 95,000.00 | 65.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 986,400.00 | 878,350.00 | 108,050.00 | 89.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 446,400.00 | 338,350.00 | 108,050.00 | 75.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4051700.00 | 5301000.00 | -1,249,300.00 | 130.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 837,000.00 | 837,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,214,700.00 | 4,464,000.00 | -1,249,300.00 | 138.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1200000.00 | 1200000.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,200,000.00 | 1,200,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 1,200,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 463,851,000.00 | 450,452,230.00 | 13,398,770.00 | 97.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 393,260,600.00 | 379,861,830.00 | 13,398,770.00 | 96.6 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 393,260,600.00 | 393,260,600.00 | 0.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 70,590,400.00 | 70,590,400.00 | 0.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 70,590,400.00 | 70,590,400.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 20.00 | 20.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 08.00 | 08.00 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **20** | **20** | 0.00 | 100.0 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 12 | 12 | 0.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 8 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **261,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **261,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 261,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 261,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 261,800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 261800.00 |

| | | |
|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 261,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 261,800.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн 1 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б. Лхагвадорж, аудиторын туслах Т. Мөнхгэрэл нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д. Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д. Отгонбаяр, аудитын менежер Э. Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А. Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн № 01 тоот албан бичгээр ирүүлсэн.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаа эрхлэх улсын төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг өөрчилсөн, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хавсралтаар шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 444.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 215.8 сая төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0.7 | 0.0 | -0.7 |
| Бараа материал | 79.9 | 93.0 | 13.1 |
| Биет хөрөнгө | 1,453.1 | 1,656.5 | 203.4 |
| Биет бус хөрөнгө | 10.6 | 10.6 | 0.0 |
| **Нийт хөрөнгө** | **1,544.3** | **1,760.1** | **215.8** |
| Дансны өглөг | 2.2 | 0.0 | -2.2 |
| Засгийн газрын хувь оролцоо | 75.8 | 75.8 | 0.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,443.6 | 1,661.5 | 217.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22.7 | 22.7 | 0.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,544.3** | **1,760.0** | **215.7** |

Бараа материалын дансны үлдэгдэл 93.0 сая төгрөг болж, 13.1 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын нөөц өсөхөд нөлөөлжээ. Тайлант хугацаанд 1.2 сая төгрөгийн аж ахуйн материал актаар хассан байна.

Биет хөрөнгийн дансны үлдэгдэл 1,656.5 сая төгрөг болж, 203.4 сая төгрөгөөр өссөн нь шинээр явган хүний зам, бохир усны цооног, гэрэлтүүлгийн самбар, бетон зам, гадна дулааны шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам ашиглалтад оруулсантай холбоотой байна. Дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 75.8 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 1,661.5 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 22.7 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 668.8 сая төгрөг, нийт зардал 450.2 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 218.6 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээтэй хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой хуримтлагдсан үр дүнд нөлөөлсөн байна. Нийт цэвэр өмчийн дүн 1,760.0 сая төгрөг байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны төсвийн төслийг 543.3 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 483.9 сая төгрөгөөр анх баталж, 20.0 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж, 463.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд 463.9 сая төгрөг батлагдсанаас 450.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 450.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 13.4 сая төгрөгийг хэмнэн, улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвөөс 10 хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваариласан хөрөнгөөс 0.3 сая төгрөгийн ариутгалын материал хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хөл хорионы үед хүүхдийн цэцэрлэгүүд хичээллэхгүй байх, мөн хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэл үүссэн. Ковидтой холбоотой төсвийн хэтрэлт, хэмнэлт гарч, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай" 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/608 дугаар захирамжаар төсвийн зохицуулалт хийгдсэн.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж, 13.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Хоол, хүнсний нормативт зардлаас 26.7 сая төгрөг хэмнэгдсэнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 9.0 сая төгрөгийн дутууг шийдвэрлүүлсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 450.4 сая төгрөгийн 151 мэдээллээс 200.0 сая төгрөгийн 75 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроохоос гадна доторхи мэдээлэл нь буруу, дутуу 250.4 сая төгрөгийн 76 мэдээллийг хугацаа хоцроож, дутуу мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим захиргааны хэм хэмжээний актын нийцлийн хэрэгжилтийг хянан үзлээ. Үүнд: Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт тус тус нийцсэн эсэхийг дүгнэн үзсэн болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хувь хүний орлогын албан татварын суутган тооцсон 2.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулах зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсвийн захирагч нарын 2021 онд төсвийг зохицуулан шийдвэрлэсэн шийдвэрийн нийцлийг авч үзэх, үндсэн хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, элэгдлийн тооцооллыг хянан үзэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8.3 сая төгрөгийн алдаа, 250.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 8.3 сая төгрөгийн алдааг залруулан, шилэн дансанд бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй 250.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар 8.3 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1 *Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой***

1.1 *Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд 250.4 сая төгрөгийн 76 мэдээллийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.

1.2 *Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” гэж заасан мэдээллийг тухай бүр шилэн дансны нэгдсэн системд мэдээлж байх,

1.3 Энэхүү зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 19 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэг | 2 | 258.7 | 1 | 8.3 | | | | | 1 | 250.4 |

1 of 1 Automatic Zoom

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | алдаа, зөрчлийн | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Түнэл сумын Хүүхдийн цэцэрлэг | 2 | 258.7 | 1 | 8.3 | | | | | 1 | 250.4 |

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.БАТ-ЭРДЭНЭ

АХЛАХ АУДИТОР Д.ОТГОНБАЯР

БЭЛТГЭСЭН:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Б.ЛХАГВАДОРЖ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР Д.ГЭРЭЛЧУЛУУН

АУДИТОРЫН ТУСЛАХ Т.МӨНХГЭРЭЛ

Аудитын код: ХӨА-2022/98/НА-СТА-ТШЗ 18